



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 314

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4,3 дахь заалт, 2019 оны 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Хархорин-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 4,218,000.00 (дөрвөн сая хоёр зуун арван найман мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Хархорин-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрахад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2019 оны 3 дугаар улиралд багтаан тайлангийн маягтаар ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА



0000571



Төрийн өмчийн бодлогын  
зохицуулалтын газрын 2013  
дугаар сарын 2-ны өдөр  
3/4 дугаар тогтоолын хамт

**"Хорин-А33А" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл**

| Машины марк, улсын<br>зориулалт, хөдөлгүүр,<br>арлын дугаар    | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон он | Нийт гүйлт<br>/км/ | Балансын үнэ /төгрөг/                                         | Хуримтлагдсан<br>элэгдэл /төгрөг/                             | Үлдэх<br>өртөг<br>/төгрөг/ | Сэргээн<br>босголтын зардал<br>/төгрөг/ | Ху<br>д<br>/   |
|----------------------------------------------------------------|-----------------------------------------|--------------------|---------------------------------------------------------------|---------------------------------------------------------------|----------------------------|-----------------------------------------|----------------|
| га маркийн 73-69<br>ын дугаартай,<br>автомашин, Арлын<br>51527 | 1993/2006                               | 80000              | 4,218,000.00                                                  | 4,218,000.00                                                  | -                          | 0.00                                    | 50             |
|                                                                |                                         |                    | 4,218,000.00                                                  | 4,218,000.00                                                  | 0.00                       | 665,900.00                              | 50             |
| <b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                           |                                         |                    | 4,218,000.00 (дөрвөн<br>сая хоёр зуун арван<br>найман мянган) | 4,218,000.00 (дөрвөн<br>сая хоёр зуун арван<br>найман мянган) |                            |                                         | 50<br>(та<br>п |